

XXI ЗУУН: ИХ МИГРАЦ, ИХ ЭКОЛОГИЙН ЗАРИМ ПРОГНОЗ*Д.Баярхүү****Нэг. Космополит өсөлтөөс их ядуурал руу**

Хүмүүн (хүн төрөлхтөн) үүсээд, өсч үржсээр 1 тэрбум болтлоо 200 мянган жилийг туулсан бол, 2 тэрбум болоход нь ердөө 130 жил зарцуулж, хэрэв өнөөгийн энэ хурдаараа явбал 2030 онд 10 тэрбум, 2070 онд 20 тэрбум, 2115 онд 80 тэрбум болж өснө.¹

Космополит онолоор “дэлхийн иргэн”, “дэлхий - ганц тосгон”, “дэлхийн тосгон” гэх ойлголтыг түлхүү номлодог. Хил хязгааргүй, чөлөөтэй нэвтрэх суурьших дэлхийн тухай ярьж бичдэг. Хүн амын миграц, нүүдэлд хязгаарлалт тавих ёсгүй, дэлхийн баялгийг хувааж эзэмших ёстой гэхчлэн. Британийн “Гардиан” сонинд 2050 оны дэлхийн хүн амын тухай АНУ-ын Худалдааны Яамны Хүн амын тооллогын товчооны прогнозыг эш татаж мэдээлжээ.² Эдүгээ 6.3 тэрбум байгаа дэлхийн хүн ам 45 жилийн дараа гэхэд 8.9 тэрбум хүрнэ. Хүүхдийн өсөлт одоогийнхоо түвшинд харин хөгшчүүлийн тоо одоогийнхоос 3 дахин өсч, дэлхий маань “өвгөрсөн” байдалд орно гэж тооцоолжээ. Тэр прогнозоор бол 88 улсад хүн амын өсөлт буурах төлөвтэй. 2002 онд дэлхийн хүн ам 74 сая хүнээр өссөн, гэтэл 1989-1990 онд 87 саяар өсч байснаас доогуур үзүүлэлт юм.

НҮБ-ын Хүн амын сангийн “Дэлхийн хүн ам-2004” илтгэлийг Лондонд танилцуулсан тус сангийн тэргүүн хатагтай Сорайя Охмед Обейдын хэлснээр, дэлхийн 169 орныг хамруулсан судалгаагаар гол төлөв ядуу буурай орнуудад хүн ам 2 дахин өсч, 1.7 тэрбумд хүрчээ. Энэтхэгийн одоогийн 1 тэрбум 80 сая хүн ам 2050 он гэхэд 1.5 тэрбум, АНУ-ын 297 сая хүн ам 408.7 сая болж өсөх ба Хятадын хүн ам 82 саяар өсч, 1 тэрбум 395 сая дээр зогсоно. Оросын хүн ам 2050 гэхэд 41 саяар багасч, 101.5 сая хүн болно.³

Хүн амын өсөлттэй зэрэгцэн нийгмийн асуудлууд шил даран хөврөх ба өлсгөлөнгөөр жил бүр 14 сая хүн, түүний дотор 6 сая хүүхэд хорвоог орхиж, зөвхөн 2000 онд 842 сая хүн байнга өлөн зэлмүүн байсны 95 хувь нь ядуу гуйлгачин орнуудад аж төрж байсан НҮБ-ын судалгаа бий.⁴ Энэтхэгийн хүн ам 500 саяар өсч Хятадаас түрүүлэх боловч тэр их хүн амын нийгмийн асуудлыг тэгш шийдэж чадахгүй. 1990 оноос хойш хөгжиж буй орнуудад хүн ам тутамд ногдох бодит орлого дунджаар 3 хувиар буурч, ядуугийн доод түвшинд аж төрөх хүн 10 гаран саяар нэмэгджээ. НҮБ-ын тооцоолсноор, 54 улсад хүн амын дундаж орлого баталгаатай

* Д.Баярхүү - Дипломатч, олон улсын харилцааны судлаач, профессор

Энд бичсэн судалгааны өгүүлэл бол түүний ГХЯ-нд эрхэлдэг ажилтай нь огт хамааралгүй бөгөөд ГХЯ-ны албан ёсны байр суурь биш гэдгийг уншигчид болгооно уу.

буурчээ. Жил бүр 11 сая хүүхэд элдэв өвчнөөр, хагас сая эх төрөлтөөр нас барж, энэ бүхний гэмтэн нь ядуурал болж байна.⁵

Хүүхэд төрүүлэх явдал дэлхий даяар буурах хандлагатай, 2050 он гэхэд үйлдвэрлэлийн өсөлтөөс төрөлт холхоцорно. ДОХ-оос шалтгаалж зарим улсад 2010 он гэхэд хүн амын дундаж наслалт 30 орчим байна. Одоо Африкт 30 сая хүн энэ аюулт өвчнөөр шаналж байна. Хэрэв ойрын жилүүдэд ДОХ-ын халдварыг эмчлэх арга нэвтрүүлэхгүй бол эдүгээ ДОХ-той яваа 45 сая хүн ойрын 10 жилд үхэж үрэгдэж дуусна. ДОХ-оос болж тухайлбал Уганд, Сенегал, Ботсван зэрэг Сахараас өмнө орших хар африкийн 38 улс маш хүнд байдалд орно. Сахараас өмнөших Африкийн орнуудад хүн амын дундаж наслалт 50 байснаа 46 болж буурсан нь ДОХ-оос үүдэлтэй. Дэлхийд дунджаар 5 хүртлэх насны хүүхдийн үхэл 100 хүн тутамд 1 (100:1) ногддог бол Африкийн энэ хэсгийн 14 улсад 5:1 харьцаатай, гэтэл өдрийн орлого нь 1 ам.долларт хүрэхгүй байна.⁶ Гэхдээ Сахараас хойшхи Африкт хүн ам өсөх хандлагатай гэнэ. Бүхэлдээ 2050 он гэхэд ДОХ нь 280 сая хүний толгой залгичихсан байх төлөвтэй.⁷ ДЭМБ-ын тооцоолсноор, жил бүр 8.5 сая хүн сүрьеэгийн халдвар авч, тэднээс 2 сая хүн үхэж үрэгдэж байна. Энэ эрчээрээ явбал 2020 онд сүрьеэтэй хүн 1 тэрбумд хүрч, өвчилсөн 150 сая хүн тутмаас 36 сая нь хорвоог орхих ажээ.⁸ Дэлхийн Банкны тооцоолсноор, 2010 он гэхэд Оросын хүн амын 4 хувь ДОХ-оор өвчилж, хуучин СССР-ийн нутагт нийт 8 сая хүн ДОХ тээгч байх бололтой.⁹ 2015 оны байдлаар дэлхийд нийт 823 сая ДОХ-тон байх ажээ.¹⁰

Хоёр. Космополит хотжилт

АНУ-ын эрдэмтэн Поль Кеннеди¹¹ мөн иймэрхүү таамаглаж, 2025-2050 онд хүн амын “тэсрэлт” гарна гэж үзжээ. 2025 он гэхэд Нигерийн одоогийн хүн ам 113 саяасаа 301 саяд, Пакистан 267 сая, Индонези 263 сая, Бразил 245 сая, Мексик 150 сая, Иран 122 саяд хүрсэн байх, Хятад 1.5 тэрбум буюу хамгийн оргил үедээ хүрнэ гэж тооцоолжээ. НҮБ-ын судалгаагаар, 2050 он гэхэд дэлхийн хамгийн ядуу буурай 50 улсад хүн ам 1.7 тэрбумд хүрэх бөгөөд ядуурал нь ийнхүү хүн амын өсөлтийг нөхцөлдүүлнэ.¹²

Хүн амын суурьшлын тухайд, хотжилт хэрээс хэтэрч, хотуудад хүн ам өсөлтөө дийлэхгүй. Эдүгээ хотжисон хүн ам Энэтхэгт нийт хүн амын 28 хувь, АНУ, Орост тус бүр 77 хувь, Индонезид 40 хувь, Бразилд 81 хувьд хүрч, хөгжиж буй орнуудад хүн амын 40 хувь нь хотод суурьшиж байна. 2025 онд энэ тоо 57 хувьд хүрнэ. Латин Америк нь тэр чигтээ хамгийн их хотжисон бүс нутаг болох нь байна. Тэндхийн хүн амын 85 хувь нь хотын иргэд байх бол Африкт 58 хувь, Азид 53 хувь нь хотод суурьших ажээ. Хүн ам нь 11 саяас дээш байх дэлхийн 20 том хотын 17 нь хөгжиж буй ертөнцийнх байна. Хотжилт, ядуурал, байгалийн гамшиг, цэргийн мөргөлдөөнөөс дүрвэж нүүх асуудал улам өргөжинө.

НҮБ-ын хүн ам зүйн судалгаагаар, 2007 он гэхэд дэлхийн хүн амын ихэнх нь хотуудад суурьшиж эхэлнэ. CNN-ийн мэдээлснээр, эдгээ дэлхийн хүн амын 52 хувь нь хөдөө сууж байна, тэгвэл 2030 он гэхэд 5 тэрбум хүн буюу дэлхийн хүн амын дийлэнх нь хотуудад суурьших ажээ. Зөвхөн ганцхан жилд л хөдөөгийн хүн ам 100 саяар хорогдож, хотуудын хүн ам 1.8 хувиар өсч байна. 2015 онд хотууд дотор Токио хүн амаараа тэргүүлнэ. Энэ хотод 36 сая хүн суух ба Бомбей 22.6 сая, Нью Дели 20.9 сая, Мехико 20.6 сая, Сан-Паулу 20 сая хүн амаараа удаалж байна.¹³

Гурав. Космополитизмын хөлд Орос

Энэтхэг, Хятадын энэ их оволзсон өсөлттэй харьцуулахад манай хойд хөрш Оросын хувьд хүн ам зүйн маш баргар дүр зураг харагдаж байна. Ерөөсөө орос үндэстэн гэж 100 жилийн дараа, XXII зуунд байх уу, үгүй юу гэдэг асуудлыг польшийн эрдэмтэн Ян Винецкий дэвшүүлж, Орос хэмээх энэ их гүрэнтэй түүхэн маргаантай асуудал нь оросуудтайгаа хамт алга болно гэж таамаглжээ.¹⁴ НҮБ-ын прогнозоор, 2000-2025 он Оросын хувьд сайн ч биш, муу ч биш гарч, хүн ам нь 21 саяар өсөхөөр байна. Коммунизмын сүйрлээр хүн амын өсөлт нь зогссон байна. 1991.12.31-ний байдлаар Оросын хүн ам 148.7 сая байсан бол 10 жилийн дараа 143.5 сая болж цөөрсөн байх ба СССР-ийн бусад улсууд дахь 5.5 сая оросууд өлгий нутагтаа эргэж ирсэн, хүн ам нь ерөнхийдөө 10 саяар хорогдсон, цөөрсөн нийлээд ийм дүнтэй байна. Хүн ам зүйн ийм таагүй байдлын гол учир шалтгаан Орост эрэгтэйчүүдийн тоо байнга цөөрч, цөөн байж ирсэнтэй холбоотой хэмээн польшийн энэ судлаач үзжээ. Харьцуулахад Оросын эрчүүд нийт дүнгээрээ Ази, Африк, Латин Америкийн хамгийн дорой буурай, ядуу орнуудын эрчүүдээс цөөн байна. Ерөөсөө XVI зуунаас хойш хүйсийн тэнцвэр алдагджээ. Орост шинээр 100 хүүхэд мэндлэхэд 170 хүн зөрөөд хорвоог орхиж, харьцаа 100:170, зөвхөн хортой архиар жилдээ 40 000 хүн нүд аньж, байна гэхчлэн элдэв тоо баримт, прогнозыг жагсааж болно. 2050 он гэхэд Оросын хүн ам 101.5 сая болно гэсэн НҮБ-ын тооцоо бий.

Орос орон хүн амын өсөлтийн хямралд орсон түүхэн шалтгааныг польш эрдэмтнээс гадна дэлхийн бусад улсад ч өргөнөөр тайлбарлаж байна. Энд юуны өмнө дэлхийн нэгдүгээр дайн, иргэний дайны хохирол, 1920-иод оны өлсгөлөн, 1930-аад оны их хэлмэгдүүлэлт, дэлхийн II дайны хохирол, эрчүүдийн дундаж наслалт 55 байгаа зэрэг бүгд нийлээд гол шалтгаан нь ажээ. Үүний сацуу Оросын газар зүйн байршил үүнд ихээхэн хамаатай. Хүн амыг тархаан жигд байршуулахад Оросын газар зүй, цаг агаар, байгалийн баялаг харилцан адилгүй. Хүн амын дөрөвний нэг нь холбооны улсынх төвийн тойргуудад (ОХУ-ын нутаг дэвсгэрийн 4 хувь) төвлөрч, нутаг дэвсгэрийн 75 хувь болдог, байгалийн асар их баялаг бүхий Зүүн Сибирь, Алс Дорнодод хүн амын 21 хувь аж төрж, жигд байршлын харьцаа хэт алдагджээ. Ингэхдээ

хүн амын 73 хувь хотуудад (АНУ-д 75 хувь нь) аж төрж байгаа ч Орост эрчтэй хөгжиж, хөгжил нь оволзож буй тийм хүчирхэг төв суурин газар алга. 2002 оны хүн амын тооллогоор 2 саяас дээш хүн ам бүхий хот Орост хоёр тоологдсон бол АНУ-д 14 байх жишээтэй.¹⁵

ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путинээс жил тутам парламентдаа илгээдэг илгээлтээс (2006 он) үзвэл, Оросын хувьд хоёр үндсэн асуудал байна. Эхнийх нь стратегийн хүчний байдал, энд хөндөж буй сэдэвт төдийлөн хамааралгүй, хоёр дахь нь энд шууд хамаатай. Оросын хувьд хамгийн ихээр түгшүүлж буй асуудал демографын байдал гэнэ. Хүн амын өсөлтийг өөд нь татахын тулд хоёр дахь хүүхдээ төрүүлсэн орос эхэд 2010 оноос 9200 ам.долларын тэтгэмж олгож байхаар В.Путин хуульчилжээ. Дунджаар 150 ам.долларын цалинтай орос хүнд 9200 гэдэг үнэхээр урамшуулал мөн.¹⁶

Миграц цагаачлалын асуудал Оросын хувьд туйлын түгшүүр төрүүлэм байна. Кавказ, Төв Ази, Хятадаас Орос руу шилжин суурьших явдал сөрөг тал руугаа хэлбийсэн, хуучин СССР-ийн нутгаас хөөгдөн ирж буй орос цөөнхийн тоо ч хэрээс хэтэрсэн, холбооны хил, цагаачлалын алба маш хүнд байдалд байгаа тухай мэдээ Оросоос тасрахгүй бололтой.

Манай өмнөд хөрш Хятадын тухайд¹⁷ Оросын геополитикч Н.Нартовын таамагласнаас эш татъя. Эдүгээ дэлхийн 72 улсад хятад иргэд аж төрж байна. 2015 он гэхэд БНХАУ-ын хүн ам дахин 300 саяар өсч, бусад улсууд дахь хятад иргэдийн миграц, суурьшлын ачаалал хэрээс хэтрэх бололтой. Зөвхөн Орост нийт хүн амын доторхи угсаатны тоогоор хятадууд 2 дугаарт орно. Энэ тоо бусад улс оронд мөн адил, ойролцоо тусна. Хятадын Өвөр Монголын Хөлөнбуйр хотын Манжуур боомтоор ОХУ-дгаргаж байгаа хүнсний ногоо, жимс жимсгэнэ нь Оросын Сибирийн оршин суугчдын хүнсний ногоо, жимс жимсгэнийн 70 хувийг эзэлж байгаа ба Манжуур боомтоор жилийн 4 улиралд Орос руу Хятадын Хэйлунзян, Ляонин, Гирин муж, Өвөр Монголоос хангалт хийгдэж байна.¹⁸ Энэ байдлаар бол манай умард хөрш хүнсий хэрэглээгээр Хятадаас бүрэн хамааралтай болжээ.

З.Бжезинский 2020 оны Хятадыг төсөөлөхдөө, ирээдүйд “Берингийн хоолойгоос Тонкины булан хүртлэх шинэ эзэнт гүрэн” нь Оросын Lenaland-ыг¹⁹ бүхэлд нь эзлэнэ 2020 он гэхэд Хятадын нөлөөний хүрээ тэлсээр “Их Хятадын” орон зай үүснэ²⁰ (Монголыг оролцуулсан, хил дагуухи нийт 20 улс) гэсэн байна.

Дөрөв. Дэлхийн экологи

Үйлдвэрлэлийн их өсөлт, хөгжлийн хурд дэлхийн байгалийн баялгийг цөллөж, олон улс орон, бүс нутаг экологийн сүйрэлд хүрэх тухай төсөөлөх нь түгээмэл болжээ. Жишээ нь 2040 он гэхэд дэлхий нефтиэ олборлож, нөөц нь шавхагдаж дуусна.²¹ Дэлхийд жилдээ 200 мянган акр ой устаж, 13 сая химийн хорт бодис агаарт цацагдаж, 130

төрлийн амьтан ургамал алга болдог гэсэн гашуун үнэний өмнө бид байна. НҮБ-ын баримтаар сүүлчийн 100 жилд манай гаригийн чийглэг гадаргууны тал нь, ой модны тал нь, нуга хөндийн 80 хувь устаж, үржил шимтэй газрын 40 хувь нь цөлжиж, загасны нөөцийн 70 хувь устаж үгүй болжээ. Амьдралыг тэтгэгч цэнгэг ус аюулын дор байна. Хязгаартай дулаан шавхагдаж, Менделеевийн үелэх схем дээрхи чухал элементүүд цаасан дээрээ үлдэх болж байна. Хүмүүний (homo sapiens) 40000 жилийн түүх төгсөх тийшээ хандаж, үлдэх хагас зуун жилд дэлхийн баялгийг тэгш хуваах их алалдааны үе хүлээж байна.²²

Тав. “Хятадын цэнхэр орон зай”

Түүнээс цааш яах вэ? У.Белло,²³ Н.Нартов нарын тооцоолсноор экологийн сүйрлээс гадна түүхий эдийн хомсдолд хамгийн түрүүн БНХАУ орохоор байна. “2025 оны Ази” хэмээх футурлогийн судалгаагаар, дэлхийн экологийн аюулгүй байдалд учрах гол аюул Хятадаас үүднэ. Байгаль, экологийн хямрал, дэлхийн цаг агаарын нөлөөгөөр 2050 он гэхэд Хөх мөрний сав дагуухи 14 хот, Дорнод Хятадын 30 хот суурин үерт нэрвэж, усанд живнэ. Иймд амьдрах шинэ орон зай хэрэгтэй болно гэжээ.

Жилдээ газаргүй болсон хятадын 10 сая тариачин хот руу шилжиж, ажилгүйдэл 15-20 хувьтай (бараг 250 сая хүн) байгаа тул “Цэнхэр орон зай” (3 сая ам.дөр.км) руу тэмүүлнэ. Байгалийн хий, газрын тос, фосфоритоор баялаг шүрэн арлууд руу Зүүн өмнөд Азийн орнууд нэгэн адил тэмүүлж буй²⁴ тул энд томхон мөргөлдөөн гарах магадлалтай. Учир нь эрчим хүчний одоогийн их алдагдал (20 хувь) Хятадыг эрчим хүчний сүйрэлд хүргэнэ. Сибирийг цөлмөх явдлыг зогсоож чадахгүй, Сибирьт байгалийн тэнцвэргүй байдал, зарим үед сүйрэл гарах магадлал их байх болно. 2030 он гэхэд Хятадын газрын тосны импортын гуравны нэгийг эндээс хангах төсөл хэрэгжинэ. Ердөө 10-аадхан жилийн өмнө Хятад нь газрын тос экспортлогч орны тоонд ордог байсан бол одоо дэлхийд АНУ-ын дараа орох том импортлогч болон хувирсан нь эрчим хүчний хэрэглээ эрс нэмэгдсэнтэй нь шууд холбоотой. Африкаас эхлэн Латин Америк хүртэл газрын тосны эрэлд хятадууд мордож, нөөц ихтэй орнуудтай түншлэх бодлого явуулах нь тодорхой байна.²⁵ Ийнхүү БНХАУ эрчим хүчний өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээгээ цаашид хангах бодлогоо шинэчилж, “газрын тос олборлох боломжтой бол хэнтэй ч түншлэх нь хамаагүй” гэсэн зарчим баримтлах болсныг шинжээчид тэмдэглэж байна.

2030 он гэхэд Хятад улс усны нөөцийн ноцтой дутагдалд нэрвэгдэж, ургацаа алдан, өвчлөл нэмэгдэж, далайн эргийн үлэмж нутаг нь усанд шивсэн байх болов уу гэсэн прогнозыг 2004 оны намар Бээжинд зохиогдсон олон улсын цаг уурчдын бага хурал дээр БНХАУ-ын мэрэгжилтнүүд өөрсдөө хийжээ. Бага хурлыг нээж БНХАУ-ын Цаг уурын газрын дарга Цинь Дахэгийн хэлсэн үг дэлхийг цочроосон юм. Тэрээр

дэлхийн глобал дулаарлаас болж Хятад улс 2030 он гэхэд усны ноцтой дутагдалд орж, жилдээ 20 тэрбум кубометр усаар гачигдана. Энэ үед хөдөө аж ахуйн гол таримлын ургац 10 хувиар унасан байх ба 2030 он гэхэд 1.6 тэрбумд хүрэх Хятадын хүн амын хүнсний хангалт хүндэрч хурцдана гэж ярьжээ. Цинь Дахэгийн хэлснээр халдварт өвчин болон халуун орны далайн шуурганаас хятадууд хүчтэй нэрвэгдэж, эргийн дагуухи хүн ард нутгийнхаа гүн рүү бөөнөөрөө нүүж, усны түвшин дээжилж, далайд хот тосгоноороо живэх аюул нүүрлэх гэнэ. Хятадын эрх баригчид ийм таагүй таамаг дэвшүүлэхдээ дэлхийн агаар мандлыг хордуулах хэмжээгээрээ дэлхийд 2 дугаарт ордог аж үйлдвэрийн хаягдлаа тооцсон хэрэг. Хэрэв Хятадын аж үйлдвэр энэ эрчээрээ хөгжвөл шат ахиж нэгдүгээрт бичигдэнэ.²⁶

Зургаа. Их гамшиг

Дэлхийн цаг уурын дулаарал, элсний нүүдэл, ойн баялгийн хомсдол, ган зуд, шар усны үер зэрэг байгалийн гамшиг дэлхийд уламжлалт бус шинэ аюулыг авчрав. Сүүлийн 10 жилд 2 тэрбум хүн байгалийн ба гэнэтийн гамшиг сүйрэлд өртөж, учирсан хохирол нь өмнөх 40 жилийн хохирлоос давсан тооцоо бий. Гамшиг, ядуурал нь хослоод эдүгээ 1 тэрбум гаруй хүн ард усны хэрэглээнээс хасагдаж, 2 тэрбум хүн ус түгээгүүрийн наад захын үйлчилгээгүй, ус дутагдаж бохирдсоноос жил бүр 3 сая гаруй хүн хорвоог орхиж байна.²⁷ 2050 он гэхэд зөвхөн үер усны гамшиг дор 2 тэрбум хүн амьдрах төлөвтэй. Далайн эргийн хотууд усанд автах, живэх явдал гарна. Эдүгээ нэг тэрбум хүн буюу хүн төрөлхтний зургааны нэг нь үер далайн шуурганы байнгын гамшиг дор аж төрж, жилдээ 25000 хүн үерт үйж, дэлхийн эдийн засагт үерээс 60 тэрбум ам.долларын хохирол амсаж байна. Энэ байдал зууны дунд үе гэхэд улам дордоно, далайн усны түвшин нэмэгдэж, олон хот тосгон боомт усан дор орно хэмээн НҮБ-ын их сургууль тооцоолжээ.

Эдүгээ дэлхийн хүн амын 70 гаруй хувь нь цэвэр ус хэрэглэж чадахгүй байна. Ууж буй ус нь бохирдсоноос өдөр бүр 25000 хүн нас барж, ус экологийн бохирдлоос шалтгаалан сахуу, улаан бурхан, астам, татран, полимиелитээр өвчлөх явдал түгээмэл байна. Энэ үзэгдэлийг XXI зуунд бүрэн арилгаж хүчрэхгүй. Хотуудын агаар, хөрс, орчны бохирдол хөгжиж буй орнуудад экологийн шинэ аюул авчирна.

Хүний хүчин зүйлийн хам нөлөөний уршгаар байгаль орчин сүйдэж, энэ нь дэлхий нийтийн сэтгэлийг түгшээсэн асуудлын нэг болжээ.. Манай хойд хөршид хүн амынх нь 60 хувь техногенийн сүйрлийн бүсэд аж төрж байна. Энэ нь 90 сая хүний аюулгүй байдлын эмзэг асуудал бөгөөд тэд 2500 химийн үйлдвэр, 1500 цацраг идэвхт бодисын, 8000 галт зэвсэг, тэсрэх бодисын, 30000 усан техникийн байгууламжийн дэргэд аж төрдөг байна.²⁸

Хойд мөсөн далайд мөсөн бүрхүүл хайлах тухайд ердөө 20 жилийн өмнө зөгнөлт уран зохиол, ирээдүй судлаач зарим эрдэмтдийн бүтээл төдийхнөөс олж үздэг байсан бол эдүгээ бодит байдал болж, 2050 он гэхэд Атлантын ба Номхон далай мөсөөр бус, усаар холбогдох болж байна. Хойд мөсөн далайгаар усан хил тогтоох асуудал Канад-Орос, Канад-АНУ, Канад-Данийн хооронд ширүүхэн маргаан өдөөнө.²⁹

Үйлдвэрлэлийг хөгжүүлэхдээ агаар, усны бохирдлын асуудлыг анхаардаггүй, байгалийн баялгийг ашиглахдаа нөхөн сэргээх ажиллагаа явуулдаггүй байсны хор уршиг өнөөдөр бидэнд ийнхүү хүндээр тусч байна. Байгаль дэлхийгээс авч болох баялгийг бүрэн хэмжээгээр авах хэрэгтэй гэсэн Оросын нэрт эрдэмтэн Н.Мичурины үзэл тэр үеийн сэтгэлгээг илэрхийлж байсан ч энэ онол эдүгээ дэлхийг сүйтгэхийг уриалсан шинжтэй харгис сургаал мэт болж байна.

Дэлхийн хэмжээний тогтвортой хөгжлийн шалгуурын үндэс нь агаар мандал, газар, түүний хэвлийн баялаг, ус, ой, амьтан, ургамлын төрөл зүйлийг хамгаалах, байгалийн нөөцийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, цөлжилт, гантай тэмцэх, химийн хорт бодис, цацраг идэвхит хаягдлыг багасгах, хог хаягдлыг боловсруулах менежмент зэрэг хүрээлэн буй орчныг хамгаалахад чиглэгдсэн нийгэм-экологийн цогц асуудал юм. Нийгэм-эдийн засгийн энэ чухал асуудлаар манай Монгол Улс дэлхийд базаахгүй үнэлгээтэй яваа тухайд элдэв нурушилт хэрэггүй. XXI зуунд хамгийн түрүүнд ой модоо барах аюултай нүүрлэнэ. Зуун гэлтгүй ердөө 10 жилийн дараа гэхэд л хожгор Монголын тухай ярих болж байна. Дэлхийн Банкнаас явуулсан судалгаа ийм дүгнэлтэд хүргэжээ.³⁰

Дүгнэж үзэхэд, XXI зууны хөгжлийн их хурд нааштай гэхээсээ сөрөг үр дагавар авчирч болохыг дээрхи прогнозын судалгаа харуулж байна. Гэхдээ хөгжиж буй ертөнц илүү ихээр хэлмэгдэх магадлал өндөр байна. Байгалийн баялгийн цөлмөлт хөгжлийн хурдтай хослоод олон улс орон, бүс нутаг экологийн сүйрэлд хүрэх тухай төсөөлөх нь түгээмэлжжээ. Ийнхүү хэлмэгдэхгүй байх гол нөхцөл бол хөгжлийн хурдыг өөртөө ашигтай эргүүлэх, тэгэхийн тулд оюуны чадамжид тулгуурласан хүчтэй оновчтой, цомхон эдийн засгийг хөгжүүлэх, ялангуяа хүнээ хөгжүүлэх, хүний хүчин зүйлийг дээд зэргээр ашиглах шаардлага зүй ёсоор тулгарах нь гарцаагүй.

ИШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. Дмитрий Петров. XXI век станет “веком Азии”, prognosis.ru /В мире/, 2005.08.10
2. *The Guardian*, 24.03.2004
3. Индусов станет больше чем китайцев, prognosis.ru /В мире/, 24.09.2004
4. A more secure world: Our shared responsibility, Report of the Secretary-General's High-level Panel on Threats, Challenges and Change, www.un.org /secureworld/

5. Мөн тэр илтгэлд
6. Мөн тэр илтгэлд
7. 50 facts show why we must change world, *The Mirror*, 6 May, 2004
8. A more secure world: Our shared responsibility, Report of the Secretary-General's High-level Panel on Threats, Challenges and Change, www.un.org/secureworld/
9. Спид грозит России катастрофой, Лондон, bbcussian.com 9/16/04
10. Мөн тэнд
11. Paul Kennedy. Preparing for the Twenty-First Century, *Fontana Press*, 1994
12. bbcussian.com 9/16/04
13. lenta.ru/world/ 2004/03/25/population/
14. "Wprost", 24.08.2005 (Польш)
15. Padma Desai. Running Out of Russians, *The Wall Street Journal*, 22.05.2006
16. Мөн тэнд
17. Н.А.Нартов. Геополитика (Учебник), М., 2000
18. Хятадын олон улсын радио, 2006.05.10
19. Лена мөрнөөс зүүн тийшхи бүх нутаг дэвсгэр
20. Zbigniew Brzezinski. A Geostrategy for Eurasia, *Foreign Affairs*, 1997, September/ October,
21. 50 facts show why we must change world, *The Mirror*, 6 May, 2004
22. Дмитрий Петров. XXI век станет "веком Азии", prognosis.ru /В мире/, 2005.08.10
23. Focus on the Global South, Bangkok University, 14.09.2000
24. lenta.ru/science/ 2004.06.14 /flood/
25. Энэ хүрээнд Хятадын Үндэсний газрын тосны корпораци 2003 оноос хойш Перу, Тунис, Азербайжан, Мавритани зэрэг 12 оронтой 20 гэрээ контракт шинээр байгуулж, 2004 онд гадаад дахь байгалийн хийн олборлолтын хэмжээгээ 2 дахин, нефть олборлолтоо 20 хувиар нэмэгдүүлжээ. Мөн дотооддоо газрын тосны эрэл хайгуулын ажлаа эрчимжүүлж, Жэзьянь мужид нефтийн стратегийн нөөц бүхий гурван сараас доошгүй хугацаагаар импортыг орлуулах тусгай орд газар бэлтгэж эхэлжээ. Улмаар Хятадын компани Америкийн "Юникол" компанийг өндөр үнээр цохиж худалдан авах санал тавьж байгаа нь Зүүн өмнөд Ази дахь АНУ-ын байгалийн шатдаг хийн болон нефтийн ордуудыг гартаа оруулах санаархал нь гэж судлаачид дүгнэжээ. 2004 онд БНХАУ-ын дарга Ху Жинтао Аргентины газрын тосны төслүүдэд Хятадын компаниуд 5 тэрбум долларын хөрөнгө оруулалт хийх тухай зарлажээ.
26. Китаю грозит климатический кошмар, prognosis.ru /В мире/, 01.09.2004
27. A more secure world: Our shared responsibility, Report of the Secretary-General's High-level Panel on Threats, Challenges and Change, www.un.org/secureworld/
28. ОХУ-ын Онц байдлын дэд сайд Михаил Фалеевийн ярьснаас эшлэв. lenta.ru. 2004/11/07 dangerous/
29. lenta.ru/articles/ 2005/08/23/polar
30. Арван жилийн дараа Монгол модгүй болно, "Ардын эрх", 2004.12.09 N07/007/